

□
**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ХАМТАРСАН ТУШААЛ/ТОГТООЛ**

2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар А/213,38

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.17 дахь хэсэг, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ/ТОГТООХ нь:

1."Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах журам"-ыг 1 дүгээр, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт - Маягт 1"-ийг 2 дугаар, "Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалт - Маягт 2"-ыг 3 дугаар, "Сонгогчдын нэрийн жагсаалтад оруулсан өөрчлөлтийг тусгасан тухай, тэмдэглэл - Маягт 3"-ыг 4 дүгээр, "Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай лавлагаа - Маягт 4"-ийг 5 дугаар, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн гадаад улсад байгаа сонгогчдын нэрийн жагсаалт - Маягт 5"-ыг 6 дугаар, "Сонгогч шилжих хүсэлт - Маягт 6"-ыг 7 дугаар, "Сонгогч шилжих хуудас - Маягт 7"-г 8 дугаар, "Сонгогч шилжин ирсэн тухай хуудас - Маягт 8"-ыг 9 дүгээр, Сонгогчийн бүртгэлийн хуудасны загварыг 10 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тушаал/тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд дарга /Г.Билгүүн/, Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга /Д.Даваа-Очир/-д даалгасугай.

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Д.ДЭЛГЭРСАЙХАН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА П.ДЭЛГЭРНАРАН**